



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 08 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

### “Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мастер шийдэл” ХХК-ийн хувьцаа эзэмшигч О.Сувдмаа нь өөрийн эзэмшлийн нэг бүр нь 10,000.00 /арван мянга/ төгрөгийн үнэ бүхий 2,000 /хоёр мянган/ ширхэг, нийт 20'000'000.00 /хорин сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг иргэн Б.Энхсанаад шилжүүлсэн тул холбогдох өөрчлөлтийг хавсралтын дагуу бүртгэсүгэй.


2. Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Мастер шийдэл” ХХК /О.Сувдмаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны .5 дугаар сарын 08-ны өдрийн  
.90 дүгээр тогтоолын хавсралт

**“МАСТЕР ШИЙДЭЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ**

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	О.Сувдмаа /ГЕ85080400/	2,000	20,000,000.00	100%	(2,000)	-	20,000,000.00	-	-	-
2	Б.Энхсанаа /ХА88042239/	-	-	-	2,000	20,000,000.00	-	2,000	20,000,000.00	100%
	<b>Нийт</b>	<b>2,000</b>	<b>20,000,000.00</b>	<b>100%</b>	<b>-</b>	<b>20,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>	<b>2,000</b>	<b>20,000,000.00</b>	<b>100%</b>